БАТЛАВ

ЗАХИРАЛ П.ДАВААЖАРГАЛ

2025 оны 05 сарын 01-ны өдөр

БАРАА НИЙЛҮҮЛЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2025-2026 оны хоолны төсөв 121788700 мянган төгрөгийн хүүхдийн хоолны материалын тендер зарлана.

Үүнээс:

Мах махан бүтээгдэхүүн-42834000

Бусад сүү, сүүн бүтээгдэхүүн, хүнсний ногоо, хатуу, хуурай хүнс-78954700 мянган төгрөгөөр тус тус худалдан авна гэж тооцоолсон.

Хоол хүнсний материал нь мах, махан бүтээгдэхүүн, гурил, будаа, төмс, хүнсний ногоо, нарийн ногоо, бусад хүнсний бүтээгдэхүүний материалаас бүрдэнэ. Эдгээр хүнсний материал нь дараах шаардлагуудыг хангасан байна.

Хоол хүнсний материалыг сар бүр хүүхдийн ирцээс хамаарч харилцан адилгүй хэмжээтэй худалдан авалт хийнэ.

Багц №1 Мах, махан бүтээгдэхүүн

Мах, махан бүтээгдэхүүнд тавигдах шаардлага:

1. Мах, махан бүтээгдэхүүн нь хүнсний бүтээгдэхүүн нь бичил биетний аюулгүй байдал болон эрүүл ахуйн шалгуур үзүүлэлтийн зөвшөөрөгдөх хэмжээ МК8 6308:2012 стандартуудын шаардлагыг хангасан нөхцөлд бэлтгэгдсэн байна.
2. Мах, махан бүтээгдэхүүн нь эрүүл ахуйн аюулгүй байдлын үндсэн шаардлага МК8 5023:2001 стандартын шаардлагыг хангасан нөхцөлд бэлтгэгдсэн байна.
3. Эрүүл ахуй, аюулгүй байдлын үндсэн шаардлага хангасан, эрүүл мал, амьтнаас бэлтгэгдсэн байна.
4. Загсаасан буюу сэврээсэн, хөргөсөн эсвэл хөлдөөсөн байдалтай байна.
5. Гулууз болон өрөөл мах нь хэвлийн цагаан шугамын дагуу тэгш ярагдсан, улаан хоолой мөгөөрсөн хоолойг бүрэн салгасан, дотор өөхний үлдэгдэлгүй, нөжирч хурсан цус, сэвс, үс шороо зэрэг гадны бохирдолгүй, гадаргуу нь урагдаж гэмтээгүй байна.
6. Тээврийн хэрэгсэл нь цэвэр, хуурай, гадны үнэргүй, хортон шавьжаар бохирлогдоогүй, шороо, чийгнээс хамгаалсан бүрхүүлтэй байх ба тогтмол ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийсэн байна.
7. Тээвэрлэлт, хадгалалт, борлуулалтын явцад технологийн горимыг чанд мөрдөнө.

Багц №2 Сүү, сүүн бүтээгдэхүүн, Хүнсний ногоо, Хатуу хуурай хүнс

Сүү, сүүн бүтээгдэхүүнд тавигдах шаардлага:

1. Сүү сүүн бүтээгдэхүүн нь сүү цагаан идээнд эрүүл ахуй, чанар аюулгүй байдлын үзүүлэлтүүдийг тогтоох баталгаажуулах MNS 1102:2006 стандартын шалгуур үзүүлэлтийн дагуу микробиологийн шинжилгээнд хамрагдсан байна.
2. Сүү сүүн бүтээгдэхүүн нь хүнсний бүтээгдэхүүн нь бичил биетний аюулгүй байдал болон эрүүл ахуйн шалгуур үзүүлэлтийн зөвшөөрөгдөх хэмжээ МК8 6308:2012 стандартуудын шаардлагыг хангасан байна.
3. Эрүүл ахуй, аюулгүй байдлын үндсэн шаардлага хангасан, эрүүл мал, амьтнаас бэлтгэгдсэн байна.
4. Хөлдөөсөн эсвэл хөлдөөсөн байдалтай байна.
5. Сүү сүүн бүтээгдэхүүнийг гадаад орчноос тусгаарлаж "MNS 5684:2006, Сав баглаа боодлын материалд агуулагдах, хүнсний бүтээгдэхүүнд шилжиж болзошгүй химийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ" стандартын шаардлага хангасан хүнсний зориулалтын уут, саванд савлана.
6. Тээврийн хэрэгсэл нь цэвэр, хуурай, гадны үнэргүй, хортон шавьжаар бохирлогдоогүй, шороо, чийгнээс хамгаалсан бүрхүүлтэй байх ба тогтмол ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийсэн байна.
7. Тээвэрлэлт, хадгалалт, боорлуулалтын явцад технологийн горимыг чанд мөрдөнө.

Хүнсний ногоонд тавигдах шаардлага:

1. Хүнсний ногоонууд нь Монгол оронд тариалагдсан МК8 0260:1982, МК8 0271:1982, МК8 0267:73, МК8 258:2006, МК8 0255:2007, МК8 0268:1973 стандартын шаардлага хангасан байна.
2. Гарал үүслийн гэрчилгээтэй байна.
3. Ил болон хамгаалагдсан хөрсөнд тариалсан байна.
4. Зориулалтын агуулах болон бэлтгэн нийлүүлэгчдээс шууд нийлүүлэгдэнэ.
5. Хүнсний ногоо нь механик элдэв хольцгүй, хортон, хөнөөлт, шавьжаар гэмтэж бохирлогдоогүй, эрүүл, цэвэр, хуурай, сортынхоо хэлбэр дүрсийг хадгалсан байна.
6. Сонгины булцуу нь нягт, ургаж соёолоогүй, ялзраагүй, хатаж чийгээ алдаагүй, хөгшрөөгүй, ааг амт сайтай байна.
7. Лууван, манжин нь нягт, шүүслэг, хөндийрөөгүй, модорч хөгшрөөгүй, өлсч үрчийгээгүй, ургаж соёолоогүй, гэмтээгүй, ялзраагүй, механик элдэв хольцгүй, гадны үнэр амтгүй байна.
8. Сармисны булцууны болц нь бүрэн гүйцсэн, цэвэр, хальс нь бүтэн, гэмтэж хагараагүй, хумсууд нь нягт, бүрхүүл хальстай, үндэс нь хуурай, шороогүй байх ба өөр өнгийн сармисны хольц байж болохгүй.

9. Төмсний хальс нь шалбарч гэмтээгүй, ногоорсон төмсгүй, пестицидийн үлдэгдэлгүй, булцуу нь нягт, ургаж соёолоогүй, ялзраагүй, хатаж чийгээ алдаагүй, хөгшрөөгүй байх, гадны ямар нэг үнэргүй, химийн бодисоор бохирлогдоогүй байна.
10. Байцаа нь нягтрал сайтай, бүтэн, цэвэр өвчлөөгүй, хортон хөнөөлт шавьжаар гэмтэж, бохирлогдоогүй, механик элдэв хольцгүй, гадны үнэр амтгүй, сортынх нь хэлбэр дүрс алдагдаагүй байна. Хадгалсан байцааг нийлүүлэхдээ гадна талын муудсан навчийг авч цэвэрлэсэн байх ба хөлдөлт, хайрагдалтгүй байна.
11. Хүнсний ногоог стандартын шаардлага хангасан шуудай, торон уутанд зэрэг, сортоор нь ялгаж савласан байна.
12. Хүнсний ногоог норох, хөлдөхөөс хамгаалж бүрхүүлтэй зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэдэг байна.

Хатуу, хуурай хүнсэнд тавигдах шаардлага:

1. Хүнсний зориулалтын сав баглаа, боодол ашигладаг байх
2. Хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг шошгонд тусгасан нөхцөлд хадгалж худалдаалдаг байна.
3. Худалдаа үйлчилгээнд шаардагдах тоног төхөөрөмж, хөргүүр, хөлдөөгчтэй байх.
4. Хүнсний зориулалтын агуулахтай байх ба агуулах нь холбогдох стандартын шаардлага хангасан, төрөжсөн байх
5. Цагаан будаа нь MNS 7301:2000 стандартыг хангасан эрүүл ахуй, аюулгүй байдлын шинжилгээнд хамрагдсан, хадгалах хугацаа хэтрээгүй байна.
6. Элсэн чихэр нь MNS CAC 4:95 стандартыг хангасан эрүүл ахуй, аюулгүй байдлын шинжилгээнд хамрагдсан, гадны хольцгүй байх.
7. Гурил нь MNS 0244:2009, MNS 0244:2003 стандартын шаардлага хангасан байх бөгөөд өнгө, үнслэг, ширхэгжилтийн хэмжээ, цавуулгийн тоо, чанарын үзүүлэлтээр талх, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэлд хэрэглэгдэхүйц байна. Буудайн гурилын хэвийн үнэртэй, исгэлэн буюу хөгцний зэрэг гадны үнэргүй байна.
8. Ургамлын тос MNS 125:1998 стандартыг хангасан эрүүл ахуй, аюулгүй байдлын шинжилгээнд бүрэн хамрагдсан, хадгалах хугацаа хэтрээгүй, цайвар шаргал өнгөтэй, тунгалаг, тунадас үүсээгүй байна.

Тусгай шаардлага

1. Бүтээгдэхүүнийг тогтоосон хугацаанд тогтмол нийлүүлж байх.
2. Стандартын шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн нийлүүлж хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлсэн тохиолдолд бүтээгдэхүүнийг буцаах ба түүнээс үүдэх хохирлыг нийлүүлэгч тал 100% хариуцаж хариуцлага хүлээнэ.
3. Нийлүүлэгч тал бүтээгдэхүүний эрүүл ахуй, аююулгүй байдлын шинжилгээний дүгнэлтийг /шаардлагатай бол тухай бүрт/ улирал бүр худалдан авагч талд өгч байна.

1. Бүтээгдэхүүний жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь

(Захиалагч дараах хүснэгтийн 1-7 дугаар багана, тендерт оролцогч тал 8 дугаар баганыг тус тус бөглөнө.)

Нэр	Бүтээгдэхүүний тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг /Ажлын талбай/	Инкотермийн нөхцлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа (Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7	8
Багц 1 Мах, махан бүтээгдэхүүн	Мах махан бүтээгдэхүүн		Кг	Сургуулийн байр	Гэрээ байгуулсан өдөр	2026-05-30	
Багц 2 Сүү сүүн бүтээгдэхүүн, Хүнсний ногоо, Хатуу хуурай хүнс	Сүү сүүн бүтээгдэхүүн, Хүнсний ногоо, Хатуу хуурай хүнс			Сургуулийн байр	Гэрээ байгуулсан өдөр	2026-05-30	